



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан
тайлан

Аудитын код: СНАГ-2024/36/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663, Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Эрдэнэзул Утас: 261729 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn Грант торнтон аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Б.Осоргарав Утас: 99113795 Цахим хаяг: info@mn.gt.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 846

танай _____-ныг № _____-г

Г ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.НАРАНЦОГТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэх Эрдэнэс ҮТП ХХК-ийг Химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн удирдлагыг хэрэгжүүлэх зориулалтаар Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулсан бол Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХК, Цемент шохой ТӨХК-иудыг хараат компанийн зохион байгуулалттайгаар ажиллуулахаар шийдвэрлэсэн байна.

Дэлхий дахинд тархсан Ковид-19 цар тахлын улмаас 2021, 2022 онд үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл үүссэн хэдий ч охин компани болох Мон-Атом ХХК нь БНФУ-ын Орано майнинг компанитай хамтран ураны төслийн үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлсэн. Эрдэнэс газ төслийн нэгж нь ОХУ-ын Газопровод союз восток ХХК-тай хамтран байгалийн хий нийлүүлэх хоолой барих төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж, батлуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт орлогыг 336,331.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 87,031.2 сая төгрөгөөр баталж, 65,915.8 сая төгрөгийн татварын зардал тооцож, 183,384.1 сая

Z:\Yewaan_Bichig\2024\0325 SNAG-56.Docx

0001930394

төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 365,409.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 53,258.8 сая төгрөг, бусад зардалд 12,073.1 сая төгрөг зарцуулж, орлогын албан татварын зардалд 74,566.6 сая төгрөгийг тайлагнаж, 225,511.3 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байна.

Эрдэнэс Монгол ХХК нь 2023 онд нэгдлийн охин, хараат компани болон харьяа хуулийн этгээдүүдэд 6 чиглэлийн 38 төрлийн үйлчилгээ үзүүлнэ гэж төлөвлөснөөс 6 чиглэлийн 28 төрлийн үйлчилгээг 456 удаа үзүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилт 8 чиглэлд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах орлого	24,745,151,989.63	183,553,075,465.15
1.1.2	Дансны авлага	13,380,544,607.62	12,399,384,810.77
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,036,904,658.09	1,905,344,513.27
1.1.4	Бусад авлага	11,339,729,010.63	43,273,011,504.40
1.1.5	Бараа материал	48,771,795.08	61,193,072.59
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	164,781,814.13	1,897,616,553.90
	Эргэлтийн хөрөнгийн дүн	50,715,883,875.18	243,089,625,920.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	137,260,392,169.83	133,442,997,053.87
1.2.2	Биет бус хөрөнгө	37,585,930.88	36,618,710.74
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,150,284,363,943.16	9,166,124,542,843.16
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө	11,873,593,356.78	16,624,403,842.49
1.2.7	Бусад эргэлтийн бус хөрөнгө	918,223,481,517.03	983,578,882,151.61
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,217,679,416,917.70	10,299,807,444,601.87
	Нийт хөрөнгийн дүн	10,268,395,300,792.86	10,542,897,070,521.95
2	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	145,215,565.59	27,017,493,308.40
2.1.1.2	Цалингийн өглөг	5,871,916.48	30,082,999.45
2.1.1.3	Татварын өр	9,531,835,187.13	83,215,929,877.28
2.1.1.4	Богино хугацаат зээл	1,016,430,397.90	1,330,996,124.11
2.1.1.5	Хүүний өглөг	1,060,085,418.25	552,696,789.18
2.1.1.6	Урьдчилж орсон орлого	-	5,379,836.00
2.1.1.7	Бусад богино хугацаат өр төлбөр	280,415,747.22	2,470,599,220.57
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,039,854,232.57	114,623,178,154.99
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	72,397,933,934.30	28,124,508,948.15
2.1.2.2	Бусад урт хугацаат өглөг	905,212,647,479.76	893,178,975,238.74
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	977,610,581,414.06	921,303,484,186.89
	Өр төлбөрийн нийт дүн	989,650,435,646.63	1,035,926,662,341.88
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч : а) Төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.2	в) Хувьцаат	5,000,000.00	5,000,000.00
2.3.3	Дахин үнэлгээний нөөц	1,498,619,291.40	1,498,619,291.40
2.3.4	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	9,149,637,563,943.16	9,165,477,942,843.16
2.3.5	Хуримтлагдсан ашиг	127,503,681,911.67	339,888,846,045.51
2.3	Эзэмшигчийн өмчийн дүн	9,278,744,865,146.23	9,506,970,408,180.07
2.4	Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	10,268,395,300,792.86	10,542,897,070,521.95

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого	64,371,595,879.32	361,015,708,840.51
2	Борлуулалтын өртөг	19,953,900,900.77	36,227,457,284.11
	Нийт ашиг (алдагдал)	44,417,694,978.55	324,788,251,556.40
4	Хүүний орлого	3,044,391,025.44	4,282,617,082.68
4	Ногдол ашгийн орлого	117,200,000,000.00	-
5	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
6	Бусад орлого	147,641,051.91	111,539,146.91
7	Ерөнхий болон удирдлагын зардал	5,145,998,503.53	12,805,328,308.81
8	Санхүүгийн зардал	12,328,559,936.69	4,337,130,561.68
9	Бусад зардал	1,284,305,281.75	12,154,880,004.14
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	(5,185,626,397.27)	253,762,510.72
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(440,706,439.30)	(60,894,242.60)
	Татвар төлөхийн өмнөх ашиг	140,424,530,497.36	300,077,937,179.48
12	Орлогын татварын зардал	4,944,291,503.63	74,566,618,974.36
	Татварын дараах ашиг	135,480,238,993.73	225,511,318,205.12
13	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг, алдагдал	-	-
14	Тайлант үеийн цэвэр ашиг	135,480,238,993.73	225,511,318,205.12
15	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
16	Бусад олз (гарз)	-	-
17	Орлогын нийт дүн	184,763,627,956.67	365,663,627,580.82

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 01 дүгээр сарын 31-нээрх үлдэгдэл	103,000,000.00	17,175,601,462.26	9,128,284,251,467.00	(7,962,596,252.03)	9,137,600,256,677.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(15,676,982,170.86)	-	(13,140,830.04)	(15,690,123,000.90)
Залруулсан үлдэгдэл	103,000,000.00	1,498,619,291.40	9,128,284,251,467.00	(7,975,737,082.07)	9,121,910,133,676.33
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	135,480,238,993.74	135,480,238,993.74
Өмчид гарсан өөрчлөлт	2,000,000.00	-	21,353,312,476.16	-	21,355,312,476.16
Зарласан ногдол ашиг	-	-	-	(820,000.00)	(820,000.00)
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	105,000,000.00	1,498,619,291.40	9,149,637,563,943.16	127,503,681,911.67	9,278,744,865,146.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(13,126,154,071.28)	(13,126,154,071.28)
Залруулсан үлдэгдэл	105,000,000.00	1,498,619,291.40	9,149,637,563,943.16	114,377,527,840.39	9,265,618,711,074.95
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	225,511,318,205.12	225,511,318,205.12
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	15,840,378,900.00	-	15,840,378,900.00
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	105,000,000.00	1,498,619,291.40	9,165,477,942,843.16	339,888,846,045.51	9,506,970,408,180.07

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	55,421,834,738.71	313,154,695,239.17
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	55,409,724,991.63	313,148,475,642.17
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,276,773.08	-
1.1.3	Бусад мөнгөн орлого	2,832,974.00	6,219,597.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	48,856,668,249.59	103,758,266,696.44
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,498,817,454.54	4,990,186,090.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	624,547,506.08	1,299,135,580.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	75,436,863.00	291,959,732.16
1.2.4	Түлш шатахуун, тээврийнхөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,626,265.00	46,469,100.00
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	20,389,805,858.94	4,854,488,265.86
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	7,751,432,271.66	60,241,659,317.13
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	132,089,767.27	11,267,910.00
1.2.8	Бусад мөнгөн зарлага	17,358,912,263.10	32,023,100,700.46
	Үндсэн үйлажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,565,166,489.12	209,396,428,542.73
2	Хөрөнгө оруулалтын үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	120,648,811,772.59	10,682,834,956.85
2.1.1	Бусад уртхугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	9,585,000.04
2.1.2	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	2,879,461,772.59	9,942,008,935.97
2.1.3	Хүлээн авсан хүүний орлого	569,350,000.00	731,241,020.84
2.1.4	Хүлээн авсан ногдол ашиг	117,200,000,000.00	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	13,774,743,868.49	46,067,213,202.62
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	449,915,690.91	1,343,936,740.00
2.2.2	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	4,038,700.00	10,000,000.00
2.2.3	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	13,320,789,477.58	44,713,276,462.62
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	106,874,067,904.10	(35,384,378,245.77)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	12,893,537,356.08	28,481,879,473.21
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	12,881,900,360.27	28,479,614,247.00
3.1.2	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	11,636,995.81	2,265,226.21
3.2	Мөнгөн зарлагын дүн	102,402,997,926.51	43,686,006,294.65
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	102,399,933,148.77	43,681,002,472.46
3.2.2	Төлсөн ногдол ашиг	820,000.00	-
3.2.3	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,244,777.74	5,003,822.19
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(89,509,460,570.43)	(15,204,126,821.44)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	23,929,773,822.79	158,807,923,475.52
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	815,378,166.85	24,745,151,989.63
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,745,151,989.63	183,553,075,465.15

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл /мян.төг/	2023 он			
				Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/	хувь
1	Нийт орлого	Мян.төг	184,763,627.90	336,331,101,661.00	365,409,865,070.10	29,078,763,409.00	108.6
1.1	Менежментийн төлбөрийн орлого	Мян.төг	2,955,492.10	231,766,651,517.00	231,973,041,393.00	206,389,876.00	100.1
1.2	Хамааралтай этгээдээс авах хүүний орлого	Мян.төг	3,044,391.00	4,626,489,014.00	4,282,617,083.00	(343,871,931.00)	92.6
1.3	Замын хураамжийн орлого	Мян.төг	61,190,653.70	99,713,561,130.00	128,818,267,447.00	29,104,706,317.00	129.2
1.4	Эрхийн төлбөр тусгай зөвшөөрөл бүхий талбай ашиглалтын орлого	Мян.төг	224,400.00	224,400,000.00	224,400,000.00	-	100.0
1.5	Үйл ажиллагааны бусад орлого	Мян.төг	117,348,691.10	-	111,539,147.10	111,539,147.00	-
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	Мян.төг	17,163,745.60	37,077,127,053.00	36,227,457,284.11	(849,669,769.00)	97.7
2.1	ГСАЗ ХХК-ийн үйлажиллагааны зардал	Мян.төг	4,865,313.50	7,971,534,799.00	7,590,921,885.00	(380,612,914.00)	95.2
2.2	ГСАЗ-ын гэрээт цагдаагийн зардал	Мян.төг	705,565.70	1,220,433,360.00	1,220,433,360.00	-	100.0
2.3	ГСАЗ-ын засварын урсгал зардал	Мян.төг	-	9,367,878,737.00	11,912,614,021.00	2,544,735,284.00	127.1
2.4	ГСАЗ-ын арчлалтын зардал	Мян.төг	-	1,676,466,706.00	980,387,710.00	(696,078,996.00)	58.4
2.5	ГСАЗ-ын элэгдлийн зардал	Мян.төг	-	16,840,813,451.00	14,523,100,308.11	(2,317,713,143.00)	86.2
2.6	Зээлийн хүүгийн зардал	Мян.төг	11,592,866.40	-	-	-	-
3	Ерөнхий ба удирдлагын зардал	Мян.төг	20,079,570.50	26,806,606,518.00	12,805,328,308.81	(14,112,346,013.00)	47.3
3.1	Цалингийн зардал	Мян.төг	2,661,050.40	7,201,304,000.00	5,210,473,823.00	(1,990,830,177.00)	72.3
3.2	Нийгмийн даатгалын шимтгэл	Мян.төг	319,660.20	898,895,000.00	668,991,821.00	(229,903,179.00)	74.4
3.3	ТУЗ холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны зардал	Мян.төг	354,377.60	2,171,048,950.00	1,152,423,725.00	(1,018,625,225.00)	53.0
3.4	Төлөөлөгчийн газрын зардал	Мян.төг	-	350,000,000.00	-	(350,000,000.00)	-
3.5	Оффис ашиглалтын зардал	Мян.төг	677,277.50	1,534,072,620.00	1,327,547,875.00	(206,524,745.00)	86.5
3.6	Бичиг хэргийн зардал	Мян.төг	41,512.70	84,921,874.00	50,058,069.00	(34,863,805.00)	58.9
3.7	Хангамжийн материалын зардал	Мян.төг	23,305.50	166,378,188.00	91,451,921.00	(74,926,267.00)	54.9
3.8	Хурал зөвлөгөөн, бусад арга хэмжээний зардал	Мян.төг	7,473.50	475,200,000.00	278,786,140.00	(196,413,860.00)	58.6
3.9	Мэдээлэл, зар сурталчилгааны зардал	Мян.төг	71,545.00	156,000,000.00	146,112,396.00	(9,887,604.00)	93.6
3.10	Гадаад албан томилолтын зардал	Мян.төг	79,180.20	411,004,399.00	224,688,703.00	(186,315,696.00)	54.6
3.11	Дотоод албан томилолтын зардал	Мян.төг	22,220.10	347,543,720.00	130,985,551.00	(216,558,169.00)	37.6

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл /мян.төг/	2023 он			
				Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/	хувь
3.12	Гэрээт ажлын зардал	Мян.төг	78,775.70	1,990,760,000.00	1,413,396,595.00	(577,363,405.00)	71.0
3.13	Машин, механизм, тоног төхөөрөмжийн сэлбэг, засвар үйлчилгээний зардал	Мян.төг	58,475.50	153,677,892.00	63,115,565.00	(90,562,327.00)	41.0
3.14	Сургалтын зардал	Мян.төг	20,690.30	291,146,000.00	341,620,803.81	(60,593,000.00)	79.1
3.15	Шуудан, харилцаа холбооны зардал	Мян.төг	26,698.40	94,798,000.00	25,806,696.00	(68,991,304.00)	27.2
3.16	Мэргэжлийн төрөлжсөн ном сэтгүүл, хэвлэлийн зардал	Мян.төг	1,329.10	11,868,000.00	6,741,957.00	(5,126,043.00)	56.8
3.17	Элэгдлийн зардал	Мян.төг	14,670,955.40	815,017,879.00	383,268,874.00	(431,749,005.00)	47.0
3.18	Татвар, төлбөр, шимтгэл, хураамж, даатгалын зардал	Мян.төг	39,289.10	7,958,526,846.00	37,707,676.00	(7,920,819,170.00)	0.4
3.19	Аудитын төлбөр	Мян.төг	36,545.50	1,394,000,000.00	1,125,753,455.00	(268,246,545.00)	80.7
3.20.	Үйлчилгээний эрхийн зардал	Мян.төг	44,702.40	190,053,150.00	67,974,171.00	(122,078,979.00)	35.7
3.21	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал	Мян.төг	-	34,050,000.00	3,081,818.00	(30,968,182.00)	9.0
3.22	Тусгай зөвшөөрлийн зардал	Мян.төг	420,880.80	69,500,000.00	55,340,674.00	(14,159,326.00)	79.6
3.23	Судалгааны ажлын зардал	Мян.төг	-	6,840,000.00	-	(6,840,000.00)	-
3.24	Хайгуул үнэлгээний зардал	Мян.төг	423,625.60	-	-	-	-
4	Санхүүгийн зардал	Мян.төг	1,097,438.20	5,184,296,984.00	4,337,130,561.68	(847,166,422.00)	83.6
4.1	Хөгжлийн банкны зээлийн хүүгийн зардал	Мян.төг	-	3,412,315,687.00	2,984,682,794.00	(427,632,893.00)	87.4
4.2	АХБ-ны зээлийн шимтгэл, хүүгийн зардал	Мян.төг	1,097,438.20	1,771,981,297.00	1,352,447,767.68	(419,533,529.00)	76.3
5	Бусад зардал	Мян.төг	5,998,343.30	17,963,209,226.00	12,154,880,004.14	(5,890,129,686.00)	67.21
5.1	Нийгмийн арга хэмжээний зардал	Мян.төг	234,885.20	371,800,000.00	241,137,151.00	(130,662,849.00)	64.8
5.2	Алданги, торгуулийн зардал	Мян.төг		9,628,446,900.00	9,577,298,197.14	59,919,101.00	100.6
5.3	Магадлашгүй зардал	Мян.төг		7,962,962,326.00	2,336,444,656.00	(5,626,517,670.00)	29.3
5.4	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	Мян.төг	5,185,626.40	-	(253,762,510.72)	(253,762,511.00)	-
5.5	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	Мян.төг	440,706.40	-	60,894,242.60	60,894,243.00	-
5.6	Үйл ажиллагааныбус зардал	Мян.төг	137,125.30	-	-	-	-
6	Татварын өмнөх ашиг	Мян.төг	140,424,530.30	249,299,861,880.00	300,077,937,179.48	50,778,075,299.00	120.3
6.1	Орлогын албан татвар	Мян.төг	4,944,291.50	65,915,767,776.00	74,566,618,974.36	8,650,851,198.00	-
7	Цэвэр ашиг	Мян.төг	135,480,238.80	183,384,094,104.00	225,511,318,205.12	42,127,224,101.00	120.3

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 165.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 165.9 сая төгрөгийн зөрчлийг давтах гаргахгүй байх 14 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 165.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гэрээ эрх зүйн хамтын ажиллагааны газрын захирлаар ажиллаж байсан албан тушаалтан албан тушаалаа урвуулан ашиглаж, ажлаас халагдсан, ажиллаж байх хугацаанд авсан 60.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгаанаас төлөгдөөгүй 34.2 сая төгрөгийн авлагыг шүүх хяналтын байгууллагад хандаж, компанийг хохиролгүй болгож, буцаан төлүүлэх шийдвэр 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр гарсан байна. 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 181/ШЗ2024/02219 дугаар анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар албадан гүйцэтгүүлэхээр болсон байна.	1	34,247.6					1	34,247.6				
Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан албан тушаалтан ажиллаж байх хугацаандаа OXFORD-ийн их сургуульд сурах сургалтын төлбөрийг компаниас төлүүлсэн байна. Гэвч тус сургуульд сурч чадаагүй ажлаас чөлөөлөгдөж, OXFORD-ийн их сургуулиас сургалтын 16.2 сая төгрөгийн төлбөрийг буцаан төлүүлсэн гэх боловч тус компанийн дансанд өнөөг хүртэл орж ирээгүй байна.	1	16,200.0					1	16,200.0				

Эрдэнэс Монгол ХХК-ийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах 8,715.9 сая төгрөгийн өртөгтэй, 33,402 м2 бетон хучилттай, үзлэгийн талбайг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж байна.	1	-					1	-				
Сангийн яамнаас 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 4-2/5989 дугаар албан бичиг (Боомтын талбай чөлөөлөх тухай) -ийг үндэслэн 2,939.9 сая төгрөгийн өртөгтэй, боомтын дэд бүтцийн хөрөнгүүдийг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр нураасан байна. Аудитын биет тооллогоор эдгээр хөрөнгүүд нь эвдэрч гэмтсэн, цаашид ашиглах боломжгүй нь ажиглагдсан. Гэвч тус хөрөнгүүдийг өнөөг хүртэл үндсэн хөрөнгө дансанд бүртгэсээр байна.	1	-					1	-				
Үйлчлүүлэгчийн тооцоолсон санхүү, татварын зорилгоор тооцсон элэгдлийн зардлын зөрүүг татварын тайлангаарх хасагдахгүй зардлын дүнтэй тулган шалгахад 80.9 сая төгрөгөөр илүү буюу зөрүүтэй тайлагнасан, мөн санхүү болон татварын элэгдлийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгийн түүхэн огноо, элэгдүүлэх өртөг харагддаггүй, олон нэр төрлийн хөрөнгийг нэг ангилалд бүлэглэж элэгдэл тооцсон зэргээс шалтгаалж, татварын зорилгоорх элэгдлийн зардал, 4,750.8 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийн дүнг давтан тооцоолох боломжгүй байна.	1	-					1	-				
Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан компанийн дүрмийн дагуу нэгдлийн нэгдсэн стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулах, охин болон хараат компанийн санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, компанийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах зорилгоор 2016 оноос өнөөг хүртэл 11-14 хувийн хүүтэй зээлийн санхүүжилтийн гэрээг 5 охин компаниудтай байгуулж, зээл олгосноос 32,842.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх, их хэмжээний авлага найдваргүй болох, охин компаниуд өрийн дарамтад орох эрсдэлтэй байна.	1	-					1	-				

<p>Эрдэнэс Монгол ХХК нь "байгууллагын бүтэц, удирдлагын чадавх, хөрөнгө оруулалтын чадавхыг сайжруулах" зорилгоор Засгийн газраас зээлийн баталгаа гаргуулан, 2016 онд Азийн хөгжлийн банкнаас 35.0 сая ам.долларын зээл авахаар гэрээ байгуулсан байна. Төсөл, хөтөлбөр хэрэгжих хугацаанд зээлийн баталгааны шимтгэлд 10,529.9 сая төгрөг, бие даасан зөвлөхүүдэд 5,722.1 сая төгрөг, зөвлөх фирмүүдэд 4,247.8 сая төгрөг нийт 9.4 сая ам.доллар буюу 21,841.6 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Гэвч компанийн бүтэц болон удирдлага төсөл хэрэгжих явцад удаа дараа солигдсоны улмаас төслийн зорилго, зорилт хэрэгжсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд үр өгөөжөө өгч, бодитой үр дүнг бий болгосон эсэх нь тодорхойгүй байна.</p>	1	-				1	-					
<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тогтоолоор батлагдсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 3.5.3 "менежментийн гэрээний дагуу охин, хараат компани, харьяа хуулийн этгээд компанид менежментийн төлбөр төлнө. Менежментийн төлбөрийн хувь хэмжээ нь борлуулалтын орлогын 2 хүртэл хувь байна" гэж заасны дагуу компани нь охин компаниудаас их хэмжээний менежментийн орлогыг төвлөрүүлсэн нь тайлант хугацаанд 300,078 сая төгрөгийн татварын өмнөх ашгийг бий болгож, 50,000 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн илүүдлийг банкны хадгаламжид байршуулсан байгаа нь уг менежментийн төлбөрийг бодитой тогтоогоогүйтэй холбоотой бөгөөд дараах эрсдэлийг бий болгож байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Менежментийн орлогыг дүрэмд заасан үйл ажиллагаанд үр ашигтай зарцуулах бодитой төлөвлөгөө байхгүй учраас өндөр ашиг, мөнгөн хөрөнгийн илүүдлийг бий болгож, өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд бий болгоогүй ашгаас 23,197.3 сая төгрөгийн ААНОАТ-ыг төлөхөд хүргэсэн байна. - Охин компаниудаас их хэмжээний хөрөнгийг өөр дээрээ төвлөрүүлснээс тэдний үйл ажиллагаандаа зарцуулах боломжийг хаах, төлбөрийн чадвар муу компаниас авлага үүсгэж, орлого бүртгэснээс хий орлогын албан татвар төлөх эрсдэлийг бий болгож байна. - Төрийн өмчит компанийн менежментийн төлбөрийн талаар зохицуулсан хууль, журам байхгүй, зөвхөн ЗГ-ын тогтоолоор дүрэмдээ тусгаснаар их хэмжээний хуримтлал бий болгож 	1	-				1	-					

байгаа нь цаашид зарцуулалтууд нь төсвийн шинжтэй үйл ажиллагаа гэж харагдах, хууль эрх зүйн хувьд ойлгомжгүй үр дагаварт хүргэх эрсдэлтэй байна.												
Эрдэнэс Монгол ХХК нь компанийн дүрмийг үндэслэн Багануур ХК, Шивээ овоо ХК, Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр, Эрдэнэс силвер ресурс ХХК, Монголросцветмет ТӨҮГ-тай 2023 оны 09 дүгээр сарын 07, 12-ны өдөр, Эрдэнэс тавантолгой ХК-тай 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр тус тус менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна. Гэвч гэрээний 7.4 "талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж батлуулснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээгээр хүлээх үүргээ зохих ёсоор биелүүлснээр дуусгавар болно" гэж заасан байхад гэрээ хүчин төгөлдөр болоогүй, менежментийн үйлчилгээ үзүүлээгүй байх үеийн төлбөрийг авахаар гэрээний хавсралтад тусгасан байна. Үзүүлсэн үйлчилгээний үр дүнг үнэлэх, тайлагнах журамгүй Менежментийн үйлчилгээний нарийвчилсан төлөвлөгөө боловсруулаагүй. Менежментийн үйлчилгээний тайланг үнэлж, баталгаажуулаагүй, тус үйлчилгээг үзүүлснээр охин компаниудын бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн болон хүний нөөцийн чадавх, бүртгэл тайлагнал, хэрхэн сайжирч ямар үр өгөөж өгч үр дүнд хүрсэн нь тодорхойгүй байна.	1	-					1	-				
Эрдэнэс Монгол ХХК-ийн өөрийн эзэмшдэг 2,781.2 га (MV-013311) ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас 200 га талбайг Шивээ овоо ХК-д ашиглах зөвшөөрөл олгож, 2009 оны 11 сарын 24-ний өдөр сар бүр 15.0 сая төгрөгийг тогтмол төлж байх нөхцөлтэй 06/99 тоот гэрээг байгуулсан байна. Гэвч тус гэрээнд төлбөр төлөлтийн хуваарь, алданги, торгууль, хариуцлагын талаар тусгаагүйгээс төлөлт хийгдээгүй байна.	1	-					1	-				
Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/145 дугаар тушаал болон 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/18 тушаалаар батлагдсан тарифын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам ашиглалтын хураамжийг Гашуун сухайт авто зам ХХК нь хураан авч, Эрдэнэс монгол ХХК-тай тооцоо нийлсэн акт үйлдэж зам хураамжийн орлогыг тушаадаг байна. Гэвч Авто зам ашиглах гэрээт компаниас бусад дамжин өнгөрсөн тээврийн	1	-					1	-				

хэрэгслээс авах зам хураамжийн төлбөрийг бүрэн хураадаг эсэхэд байнгын хяналтыг тавьж чаддаггүй, аудитын биет тооллогын ажиглалтаар боомтоор нэвтрэн өнгөрч байгаа суудлын автомашинаас зам ашигласны хураамж авахгүй байгаа нь ажиглагдсан. Энэхүү сул мөнгөн урсгалыг хянах үйл ажиллагаа дутагдалтай байна.												
Зэс металлын группийн даргатай үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг өсгөх зорилгын хүрээнд сар бүр 15.0 сая төгрөгийн үндсэн цалинтай, группийн даргын үүргийг аливаа гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй байх онцгой нөхцөл бүхий гэрээг байгуулан ажилладаг байна. Гэвч гэрээгээр хүлээсэн үүрэгт ажлыг хөндлөнгийн 3 иргэнээр гүйцэтгүүлэхээр тус бүр 12.0 сая төгрөгийн ажлын хөлстэй, нийт 36.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулан гүйцэтгүүлж үргүй зардал гаргасан байна.	1	36,000.0					1	36,000.0				
Эрдэнэс Монгол ХХК, ажилтан, үйлдвэрчний эвлэлийн 3 талт "Хамтын гэрээ"-ний дагуу тус компани нь тэтгэвэрт гарч буй ажилтнуудаа тэтгэмж олгох үүрэг хариуцлагыг хүлээсэн боловч ирээдүйд хүлээх өнөөгийн үүрэг хариуцлагын нөөц өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй байна. Энэ нь санхүүгийн тайланд үлэмж хэмжээгээр нөлөөлөх, материаллаг дүн бүхий хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд үүсгэхээр байна.	1	-					1	-				
Санхүүгийн программаас татагдаж байгаа санхүүгийн мэдээллийн иж бүрэн байдлыг шалгахад Авлага, өглөгийн насжилтын тайлан бэлтгэгддэггүй, Гадаад валютын ханшийн тооцооллыг автоматаар хийдэггүй, гараар тооцож бүртгэдэг, Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэгддэггүй, Санхүүгийн тайлангуудыг программаас оронгийн нарийвчлалын зөрүүтэй гардгаас шалтгаалж, гараар бэлтгэдэг, Санхүү болон татварын зорилгоор тооцсон элэгдлийн тайлангийн дүн зөрүүтэй гардаг зэргээс үүдэн Санхүүгийн тайланг НББ-ийн тухай хууль, СТОУС, НББОУС-ийн дагуу үнэн зөв бодитой тайлагнаагүй байх эрсдэлтэй байна.	1	-					1	-				

Илүү цагаар ажиллах зөвшөөрөл аваагүй, ажилласан цагийн бүртгэл хөтлөөгүй ажилтан, албан хаагчдад Гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/299 дүгээр "Нэмэгдэл хөлс олгох тухай" тушаалаар (97 албан хаагчдад), 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/306 дугаар "Нэмэгдэл хөлс олгох тухай" тушаалаар (21 албан хаагчдад) нийт 79.5 сая төгрөгийн илүү цагийн хөлс тооцон олгосон байна.	1	79,505.0					1	79,505.0				
Дүн	14	165,952.6	-	-	-	-	14	165,952.6	-	-	-	-